

## САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫНЗОРИЛГО

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 1а/5063 тоот албан бичиг, Булган аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн А/693 тоот захирамж, Санхүүгийн хяналт аудитын албаны даргын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/23 тоот удирдамжийн дагуу Булган аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Монгол улсын санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгах, илэрсэн зөрчил дутагдалд дүгнэлт өгөх, засаж залруулахад чиглэгдлээ.

### ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд, дотоод аудитор П.Азхишиг нар 2022 оны 11 дүгээр сарын 22-ноос ажлын 8 хоногт багтаан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

### ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020, 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулга ншалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, хоол эм, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

### ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган сумын 5-р багт байрлах 9014624 регистрийн дугаартай Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь 2019-2020 оны хичээлийн жилд “Чадамжид суурилсан сургалтын технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, дадлагын сургалтын чанар үр дүнг

дээшлүүлэхэд бодитой ахиц гаргана” зорилт, 2020-2021 оны хичээлийн жилд “Сургалтын орчинг сайжруулах замаар судалгаа шинжилгээ, инноваци, мэдээллийн технологид суурилсан сургалтыг зохион байгуулж зөв хандлагатай иргэнийг бэлтгэнэ” зорилт дэвшүүлэн ажилласан байна. Сум орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, захиалга, суралцагчдын эрэлт хэрэгцээг үндэслэн энэ хичээлийн жилд авто тээвэр, иргэний барилга, байгууламж, хүнсний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэр, хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, үйлчилгээний чиглэлээр нийт 293 суралцагч суралцсан байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь захиргаа аж ахуй, сургалтын алба гэсэн 2 албатай, 2020, 2021 онд бүтэц орон тоо баталсан тушаал шийдвэр гаргаагүй ба 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс дарга 1, менежер 2, нягтлан бодогч 1, хяналт шинжилгээ үнэлгээ, мониторинг хариуцсан ажилтан 1, нярав-1, хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан-1, бичиг хэрэг, архивын ажилтан 1, арга зүйч 1, эмч 1, нийгмийн ажилтан 1, ХАБЭА хариуцсан ажилтан 1, НТХЗЗСС Хариуцсан ажилтан 1, ЦТТМСС хариуцсан ажилтан 1, багш 25, дотуур байрны багш 3, тогооч 1, туслах тогооч 1, үйлчлэгч 6, жижүүр 1, мужаан 1, сахиул 3 гэсэн нийт 55 ажилтантай сургалтын үйл ажиллагааг явуулж ирсэн байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 1-р дүгээр гарын үсгийг 2020 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл захирал Ч.Оюунтуяа, 2-р дугаар гарын үсгийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 11-ны өдөр хүртэл М.Батсүх, 2020 оны 03 дүгээр сарын 12-ны өдрөөс 2021 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл нягтлан бодогч Д.Цэцэгдэлгэр нар тус тус зурсан байна. Төрийн санд бүртгэлтэй 100040037009 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох “Acolous” программаар бүртгэж хөтөлсөн байна.

#### ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тайлан баталгаажуулалтаар 2020 оны санхүүгийн тайлан зөрчилгүй дүгнэлт өгч 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгсөн байна.

2021 оны санхүүгийн тайланд Бейкер Тилли Далайван Аудит ХХК аудит хийж зөрчилгүй дүгнэлт өгсөн байна. Ажлын даалгавраар анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 90.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн төлбөрийн акт тогтоож 4 зөвлөмж хүргүүлсэн байна.

#### ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2020 он: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2020 онд төсөв, гүйцэтгэлийн 56 мэдээлэл оруулахаас 49 мэдээллийг хугацаанд нь, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 42 мэдээллийг оруулахаас 33

мэдээллийг хугацаанд нь бусад 66 мэдээлэл оруулахаас 54 мэдээллийг хугацаа хугацаанд нь, нийт 28 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

2021 он: Төсөв, гүйцэтгэлийн 53 мэдээлэл оруулахаас 50 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээлэл хугацаа хоцроож, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 42 мэдээллийг оруулахаас 40 мэдээллийг хугацаанд нь 2 мэдээлэл хугацаа хоцроосон, бусад 65 мэдээлэл оруулахаас 62 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

## ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Булган аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2020, 2021 оны төрийн сангийн харилцахын баримт, няравын бараа материалын баримт, жилийн эцсийн хөрөнгийн тооллогын бүртгэл, төсвийн шууд захирагчийн гаргасан А, Б тушаал, цалингийн карт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, ирсэн явсан бичиг, санхүүгийн тайлан, төрийн аудитын байгууллага болон бусад байгууллагаас хийсэн шалгалтын материал зэрэг холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч Д.Цэцэгдэлгэрийг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв

### 8.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2020 онд улсын төсвөөс 1354730.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан бөгөөд үүний 99.8 хувийг буюу 1352559.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 0.2 хувийг буюу 2171.0 мянган төгрөгийгүндсэн үйл ажиллагаанаас орсон орлого байна.

Төсөвт зардлыг 1372559.4 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 768534.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 95402.5 мянган төгрөг, тогтмол зардалд 282768.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 28185.5 мянган төгрөг, норматив зардалд 13187.6 мянган төгрөг, томилолтын зардалд 127.0 мянган төгрөг, бусад зардалд 44638.3 мянган төгрөг нийт 1293224.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалаас зарцуулсан байна.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв 2021 онд өөрийн орлогоос 9331.4 мянган төгрөг, улсын төсвөөс 1436940.3 мянган төгрөгийн санхүүжилт нийт 1446271.7 мянган төгрөгийн эх үүсэртэй 1418438.9 мянган төгрөг зарцуулж 27832.8 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

2021 онд Цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 800240.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 102567.4 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 3826.0 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 295936.4 мянган төгрөг, цэвэр, бохир усны зардалд 11765.6 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1866.3 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1538.5 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 2722.7 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,

ариутгалын зардалд 3012.6 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 2229.3 мянган төгрөг, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлийн зардалд 323.2 мянган төгрөг, хоол хүнсний зардалд 8307.9 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд 2711.2 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 1346.4 мянган төгрөг, урсгал засварын зардалд 9640.8 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 127.0 мянган төгрөг, даатгалын үйлчилгээний зардалд 1258.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн татварт 81.5 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн оношлогооны зардалд 33.0 мянган төгрөг, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардалд 742.5 мянган төгрөг, газрын төлбөрт 3.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 23345.3 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 94246.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 49444.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 1122.0 мянган төгрөг нийт 1418438.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар: 2020 онд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлын Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5-р тогтоолыг үндэслэн 2020 оны 3-р сарын 31-ны “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” А/21 тоот тушаалаар 1-р улиралд 53 албан хаагчдад 14996.1 мянган төгрөг, сургуулийн захирлын 2020 оны 6-р сарын 9-ны өдрийн “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” А/30 тоот тушаалаар 2-р улиралд 25 албан хаагчдад 7514.4 мянган төгрөг, сургуулийн захирлын 2020 оны 09-р сарын 22-ны “Үр дүнгийн урамшуулал олгох тухай” А/48 тоот тушаалаар 3-р улиралд 49 албан хаагчдад 5863.0 мянган төгрөг, сургуулийн захирлын 2020 оны 12-р сарын 14-ны А/75 тоот тушаалаар 4-р улиралд 49 албан хаагчид 13996.8 мянган төгрөг нийт 42370.3 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалт цалин урамшуулал олгожээ. Мөн сургуулийн захирлын сар бүр гаргасан ур чадварын нэмэгдэл олгох тушаалаар 22 албан хаагчид 28317.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна. 2020 оны 10-р сард ажилтнуудад захирлын тушаал шийдвэргүйгээр ур чадвар бодож олгосон.

Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Ч.Оюунтуяа нь 1-р сард 2019 оны ажлын дүгнэсэн Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 01-р сарын 13-ны өдрийн “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай” А/02 тоот тушаалаар 896.2 мянган төгрөг, 2-р улиралд Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай” А/160 дүгээр тушаалаар 448.1 мянган нийт 1344.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

2021 онд: Захирлын А/12 тоот тушаалаар 13 ажилчидад 14-25%-аар 1561.3 мянган төгрөг, А/17 тоот тушаалаар 15 ажилчдад 10-25%-аар 1573.0 мянган төгрөг, А/26 тоот тушаалаар 15 ажилчидад 1760.3 мянган төгрөг, А/34 тоот тушаалаар 15 ажилчидад 10-25%-аар 1674.2 мянган төгрөг, А/42 тоот тушаалаар 10-23%-аар 1902.3 мянган төгрөг, А/50 тоот тушаалаар 15 ажилчидад 1858.8 мянган төгрөг, А/55 тоот тушаалаар 2 ажилчидад 116.7 мянган төгрөг, А/58 тоот тушаалаар 15 ажилчидад

1715.9 мянган төгрөг, А/70 тоот тушаалаар 10-25%-аар 1806.6 мянган төгрөг, А/81 тоот тушаалаар 17 ажилчдад 2157.1 мянган төгрөг, А/91 тоот тушаалаар 17 ажилчдад 1404.5 мянган төгрөг, А/103 тоот тушаалаар 22 ажилчдад 22-25%-аар 3089.1 мянган төгрөг нийт ур чадварын нэмэгдэл 20619.8 мянган төгрөг, А/27 тоот тушаалаар 1-р улирлын үр дүнгийн урамшуулал 47 багш ажиллагсадад 20-40%-аар 12105.2 мянган төгрөг, А/51 тоот тушаалаар 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал 48 багш ажиллагсадад 8331.8 мянган төгрөг, А/69 тоот тушаалаар 3 дугаар улирлын урамшуулалд 42 багш ажиллагсадад 5216.1 мянган төгрөг, А/104 тоот тушаалаар 4 дүгээр улирлын урамшуулалд 50 багш ажиллагсадад 12564.5 мянган төгрөг нийт 58837.4 мянган төгрөг олгосон байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 10 дугаар сарын 11-ны өрийн А/161 тоот тушаалаар 3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал 45%-аар 448.1 мянган төгрөг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/122 тоот тушаалаар 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс олгохоор шийдвэр гарч 2021 онд 2480.5 мянган төгрөг олгосон байна.

Тэтгэмж: Захирлын 2021 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Б/19 тоот тушаалаар мэргэжлийн боловсролын салбарт 5 жил тасралтгүй ажилласан багш С.Хонгорзул, П.Болормаа, Т.Солонго, П.Нямдаваа, Н.Дэмбэрэлтуяа, Д.Оргил нарт хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж 49444.2 мянган төгрөг, Б/18 тоот тушаалаар дотуур байрны тогооч Б.Нарантуяа, үйлчлэгч Б.Хишигбат, И.Сарангэрэл нарт өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж 31149.0 мянган төгрөг, 05 дугаар сарын 17-ны өдрийн Б/31 тоот тушаалаар автомашины засварчин мэргэжлийн багш Г.Энхбаярт өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 31131.6 мянган төгрөг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Б/39 тоот тушаалаар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Ч.Оюунтуяад тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж 31965.8 мянган төгрөг олгосон байна.

## 8.2. Өглөг, авлагын талаар:

2020 онд Тус Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал нь 2020 оны эхэнд ажилчидтай / цалингийн/ холбогдсон 1188.1 мянган төгрөгийн, байгууллагад төлөх өглөг буюу татварын 27.7 мянган төгрөгийн өглөг нийт 1215.9 мянган төгрөгийн өглөг, ажилчидтай холбогдсон 4151.8 мянган төгрөгийн авлага, байгууллагаас авах 109.0 мянган төгрөгийн авлага, хоолны 34.6 мянган төгрөгийн авлага, хувь хүмүүсээс авах 119.5 мянган төгрөгийн авлага нийт 4380.3 мянган төгрөгийн авлагатай байсан ба жилийн эцэст хувь хүмүүст төлөх өгөх өглөг /хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь хүнээс суутгах татварт хөнгөлөлт үзүүлэхгүй суутган авч тайлагнасан /7694.3 мянган төгрөгийн өглөг, байгууллагад төлөх буюу ҮЭ-д өгөх 4.8 мянган төгрөгийн өглөг нийт 7699.1 мянган төгрөгийн өглөгтэй, байгууллагаас авах буюу Татварын авлага /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувь хүнээс суутгах татварын хөнгөлөлтийг шилжүүлж тайланг засварлаагүйгээс үүссэн/ 7694.3 мянган төгрөг, хувь хүмүүсээс

авах буюу ҮЭ-ээс 4.8 мянган төгрөгийн авлага нийт 7699.1 мянган төгрөгийн авлагатай тайлан гарсан байна.

2021 онд өглөг 626.2 мянган төгрөгийн /цэвэр бохир ус 609.9 мянган төгрөг, хувь хүмүүст өгөх өглөг 16.3 мянган төгрөг/, авлага 3510.7 мянган төгрөг /түлш халаалтын авлага 3494.4 мянган төгрөг, бусад зардлын тооцооны авлага 2.3 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 14.0 мянган төгрөг/ тайлан гарсан байна.

### 8.3. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

2020 онд: Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4198413.9 мянган төгрөг дээр төсвийн хөрөнгөөр 6637.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандив тусламжаар 14015.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 441.9 мянган төгрөгийн ном орлогод авч нийт 21094.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 10-р сарын 08-ны өдрийн “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 492 тоот тогтоолоор 9526.7 мянган төгрөгийн хөрөнгийг тоног төхөөрөмж данснаас хасажоны эцэст 4209981.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2021 онд: Тайлант хугацааны эхэнд барилга байгууламж 2668358.4 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 30268.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 871370.9 мянган төгрөг, тавилга эд хогшил 80483.3 мянган төгрөг, зам гүүрийн барилга байгууламж 265.0 мянган төгрөг, номын фонд 22298.1 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 235905.7 мянган төгрөг, программ хангамж 19441.9 мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 281590.0 мянган төгрөг нийт 4209981.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсанаас бусад эх үүсвэрээс 15458.1 мянган төгрөгийн хөрөнгө орлогодож Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 04 сарын 05-ны өдрийн 100 тоот тогтоол, 2021 оны 11 сарын 11-ны өдрийн 522 тоот тогтоолоор авто тээврийн хэрэгсэл 13868.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 664256.1 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 69685.4 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 8358.9 мянган төгрөг, программ хангамж 3731.9 мянган төгрөг нийт 759900.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж 3465539.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

### 8.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

2020 он: Оны эхний үлдэгдэл 96340.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 6729.2 мянган төгрөгөөр эм боох, 22767.5 мянган төгрөгөөр бэлэн бүтээгдэхүүн, 1897.0 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 12235.8 мянган төгрөгөөр аж ахуйн материал, 3741.7 мянган төгрөгөөр түлш шатах тослох материал, 13521.6 мянган төгрөгөөр барилгын засварын материал, 8841.2 мянган төгрөгөөр хүнсний материал, хандиваар 1601.3 мянган төгрөгийн эм боох, жилийн үйл ажиллагаандаа 50569.3 мянган төгрөгийг зарцуулан, оны эцэст 117131.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2021 он:Тайлант оны эхний бараа материалын үлдэгдэл 117131.2 мянган төгрөг төсвийн хөрөнгөөр 49296.5 мянган төгрөгөөр тусгай зориулалтын материал, 825.7 мянган төгрөгөөр эм боох материал, 19614.3 мянган төгрөгөөр бэлэн бүтээгдэхүүн 1801.3 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 7568.0 мянган төгрөгөөр аж ахуйн материал, 1538.5 мянган төгрөгөөр түлш, шатах тослох материал, 9640.8 мянган төгрөгөөр барилга засварын материал, 8307.9 мянган төгрөгөөр хүнсний материал худалдан авч, 10 дугаар сарын 04-ны А/77 тоот тушаалаар бүртгэлгүй 106 нэр төрлийн 397 ширхэг 51751.5 мянган төгрөг, 12 дугаар сарын 31-ний өдрийн А/110 тоот тушаалаар 74 нэр төрлийн 439 ширхэг 94181.0 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж 50355.1 мянган төгрөгийн материал зарцуулж 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/23 тоот тогтоолоор 400 нэр төрлийн 6786.65 ширхэг 39748.3 мянган төгрөг, 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/75 тоот тушаалаар 55 нэр төрлийн 5279.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж 251903.4 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

#### ЕС. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

1. Анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн.
2. Шинээр авсан болон хандив тусламжаар ирсэн хөрөнгийг тухай бүр шийдвэр гаргаж данс бүртгэлд тусгасан .
3. Өмч хамгаалах зөвлөл 5 удаа хуралдаж хөрөнгийг данс бүртгэлд тусгах, акта, урсгал засвар хийх шийдвэрийг холбогдох албан тушаалтанд хандан шийдвэрлүүлсэн, ашиглагдахгүй болсон эд хөрөнгийг 2021 онд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2 удаа шийдвэр гаргуулж данс бүртгэлээс хасаж дахин ашиглагдах хөрөнгийг бүртгэж авсан. Акталж усгасан хөрөнгийг баримтжуулсан байна. Данс бүртгэлд тусгагдаагүй байсан 106 нэр төрлийн 397 ширхэг 51751.5 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж авах тушаал гаргаж тусгасан байна.

#### АРАВ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Сахиул, жолооч Л.Дамбад 1 хоног, сахиул Д.Алтанбаганад 2 хоногийн ээлжийн амралтын олговор 156.3 төгрөгийг цалинтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/-д, Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-д /Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна./-д заасныг тус тус зөрчиж байна.
2. Ажлын хэсэг томилсон 32 тушаалд дотоод журмын 9.5 дах заалт, суралцагчдыг хасах тухай 2 тушаалд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн дүрмийн 6.1

дэх заалт, суралцагчдийн сургалтын гэрээний 6.2, 6.4 дэх заалтуудыг үндэслэн тушаал гаргасан.

3. Хүнсний тайлан ойлгомжгүй гаргасан, агуулахын бүртгэл дутуу хөтөлсөн зэрэг зөрчлүүд илэрлээ.

#### **АРВАН НЭГ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор улсын байцаагчийн 1 актаар мянган төгрөгийн 156.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож шалгалтын хугацаанд 1 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### **АРВАН ХОЁР. ДҮГНЭЛТ**

Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэлт сайн, эмх цэгцтэй үдэгдсэн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилт хангалттай байна гэж дүгнэлээ.

#### **АРВАН ГУРАВ. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ**

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийх Тушаалд хуулийн зүйл заалт үндэслэж байх.

Хоолны өдөрлөгийн түүврийг нэгтгэж хүнсний тайланг зөв гаргах, агуулахын бүртгэлийг тухай бүр хөтлөх.

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх;

**ХЯНАСАН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ** **Б.БАТТУЛГА**

**БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ** **Л.ЦЭРЭНБҮТЭД  
П.АЗХИШИГ**



2021 онд захирал 1, сургалтын менежер 1, арга зүйч 2, нийгмийн түншлэл үйлдвэр сургалт хариуцсан арга зүйч 1, нийгмийн ажилтан 1, ЦСАХ сургалтын нөөц хариуцсан ажилтан 1, дотуур байрны багш 2, мэргэжлийн багш 28, ЗАА менежер, эмч 1, нягтлан бодогч 1, нярав 1, захирлын туслах бичиг хэрэг 1, тогооч 2, үйлчлэгч 5, сахиул 3, жижүүр 1, мужаан 1, тогоочын туслах 1, слесарь цахилгаанчин 1 бүгд